



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 51

Есөнбулаг сум

2017 онд ойгоос бэлтгэх түлээний модны
хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/111 тоот тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн шинэсэн ойд цэвэрлэгээний ажил хийх замаар түлээний мод бэлтгэх сумдын нэр, цэвэрлэгээ хийх талбай болон түлээний хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Ойн цэвэрлэгээний ажил явуулах талбай тусгаарлан, цэвэрлэгээний ажлын явцад технологийн хяналт хийн, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулж ажиллахыг Сум дундын ойн ангийн дарга /Б.Эрдэнэбаяр/-д, цэвэрлэгээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ойг зохих журмын дагуу хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Д.Батмагнай/-д тус тус даалгасугай.

3. Цэвэрлэгээний ажлын дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга /Д.Батмагнай/, Сум дундын ойн ангийн дарга /Б.Эрдэнэбаяр/ нарт даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ



0200254

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 31-ний
өдрийн 51-р тогтоолын хавсралт



№	Сумдын нэр	Талбайн хэмжээ /га/	Бэлтгэх түлээний хэмжээ
1	Жаргалан	30	300
2	Халиун	40	400
3	Есөнбулаг	30	295
Нийт дүн			

-----o0o-----